



Ерөнхийлөгч Томас С.Монсон

## Ариун газар зогсогтун

*Түүнд хандсан бидний залбирлууд, бидэнд өгдөг Түүний сүнслэг өдөөлт болон Тэнгэр дэх Эцэгтэйгээ харилцах харилцаа нь амьдралын шуурга, саад бэрхшээлүүдийг даван туулахад бидэнд нэн чухал юм.*

**Х**айрт ах эгч нар аа, бид өнөөдөр гайхалтай сайхан захиасуудыг сонслоо. Чуулганд оролцсон хүн бүрийг би сайшаахыг хүсч байна. Бид ялангуяа Ахлагч Роберт Д.Хейлсийн бие нь сайжран бидэнтэй эргэн нэгдсэнд маш их баяртай байна. Боб, бид чамд хайртай шүү.

Энэ өглөө та нарт юуны тухай ярихаа тунгаан бодох зуураа би чухал, цагаа олсон хэдэн тодорхой санаа бодол, мэдрэмжүүдийг хуваалцах хэрэгтэйгээ ойлгосон юм. Сүнсээр удирдагдан яриагаа өгөхийн төлөө би залбирч байна.

Энэ дэлхий дээр би 84 жилийн турш амьдарчээ. Чарлис Линдберг анх удаагаа Нью-Йоркоос Парис хүртэл ганц мотортой, нэг суудалтай онгоцоор зогсолтгүй ниссэн онд би төрсөн билээ. Түүнээс хойш 84 жилийн турш олон зүйл өөрчлөгджээ. Хүн сар руу нисэж, эргэж ирснээс хойш олон жил улиран одсон байна. Үнэндээ өчигдрийн зөгнөл өнөөдрийн бодит байдал болсоор байна. Тэр бодит байдал болох өнөө үеийн дэвшилтэт

технологи маш түргэн өөрчлөгдөн хөгжиж байгаа тул түүнтэй хөл зэрэгцүүлэн алхах нь бидэнд томхон сорилт болж байна. Энгийн утас, бичгийн машинаас илүүт мэддэггүй бидний хувьд өнөөгийн техник технологи зөвхөн гайхамшигтай гэхээс илүү зүйл болжээ.

Мөн нийгмийн ёс суртахуун маш түргэн өөрчлөгдөж байна. Урьд нь зохисгүй, ёс суртахуунгүй хэмээн үзэгдэж байсан хандлага, зан байдлуудыг өнөөдөр олон хүмүүс энгийн зүйл мэтээр харах болжээ.

Саяхан би *Wall Street Journal* дээр гарсан Жонатан Саксын Британы Иудей шашны удирдагчийн тухай өгүүллийг уншсан юм. Тэрээр ийн бичжээ: “1960-аад онд Барууны бараг бүх соёл иргэншилд ёс суртахууны огцом өөрчлөлт гарч, хүмүүс өөрсдийн зан төлвийг хязгаарлан барьж, хувь хүнийг төлөвшүүлэх уламжлалт ёс суртахуунаа гээцгээжээ. Та бүгдэд хэрэгтэй зүйл бол хайр хэмээн Битлз хамтлаг дуулж байв. Христийн шашинд уламжлалт ёс суртахууны жишиг орхигдсон байна. Харин түүний

оронд: *[Хүссэн бүх зүйлээ [хий] хэмээн өөрчлөв.* Арван зарлиг Арван бүтээлч зөвлөмж болон дахин бичигджээ.”

Тэрээр үргэлжлүүлэн ихэд гунигтайгаар ийн бичжээ:

“Өөрсдийн ёс суртахууныг бид хөрөнгө мөнгөө үрэн таран хийж байгаа мэт л хайнга хаяж байна . . .

[Дэлхийн] ихэнх хэсэгт шашин нь улирч одсон зүйл болж, та нар үүнийг хүртэх гавъяатай тул юу дуртайгаа худалдаж авч, мөнгөө үрж, гоёмсог хувцас өмсөж, өөрийн гоо сайхныг бусдад гайхуул гэх үзлийн эсрэг зогсох бодит дуу хоолой үгүй болжээ. Ёс суртахуун нь хоцрогдож цагаа элээсэн зүйл бөгөөд сүсэг бишрэл нь сул дорой хүмүүст зориулсан зүйл гэж тунхаглаж байна. Бүхний дээрх цорын ганц зарлиг бол ‘Чи бүү баригд’ болжээ.’”<sup>1</sup>

Хайрт ах эгч нар минь, харамсалтай нь биднийг хүрээлэн байгаа дэлхийг ингэж дүрсэлж болох юм. Бид нар ийм дэлхийд тэсч гарч чадах болов уу хэмээн өөрсдөөсөө асуун санааширч байна уу? Үгүй ээ. Харин ч бидний амьдралд Есүс Христийн сайн мэдээ байгаа төдийгүй бид ёс суртахуун нь хуучирч орхигдоогүй, сүсэг бишрэл нь биднийг удирдагч бөгөөд хүмүүс үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг гэдгийг мэддэг.

Хэдийгээр дэлхий өөрчлөгдсөнч гэсэн Бурханы хуулиуд хэвээр үлдэнэ. Тэдгээр нь өөрчлөгдөөгүй бөгөөд өөрчлөгдөх ч үгүй. Арвин Зарлиг нь Арван Зарлиг хэвээрээ л үлдэнэ. Тэдгээр нь *зөвлөмж* биш. Эдгээр зарлиг нь Бурхан Израилын

хүүхдүүддээ өгөх үед чухал байсан шиг өнөөдөр ч чухал хэвээр байна. Хэрэв бид зөвхөн анхаарал хандуулах аваас яг одоо энд бидэнд хандан ярьж буй Бурханы дуу хоолойг сонсох болно.

“Чи надаас өөр бурхадтай байж болохгүй.

Чи өөртөө зориулж шүтээн бүү хий. . . .

Чи өөрийн Бурхан Эзэний нэрийг дэмий бүү дурд. . . .

Амралтын өдрийг ариунаар сахирын тулд санагтун. . . .

Эцэг эхээ хүндэл. . . .

Чи хүн бүү ал.

Чи бүү завхайр.

Чи бүү хулгайл.

Чи худал бүү гэрчил. . . .

Чи бүү шунахайр.”<sup>2</sup>

Бидний мөрдөх ёстой зүйлс нь хувируулж мөн тохиролцож болох зүйл биш. Энэ нь зөвхөн Арван зарлигт байдаг төдийгүй Аврагчийн маань Уулан дээрх номлолынхоо үеэр өгсөн зарлигуудад бас бий. Эдгээрийг Түүний заасан сургаал бүрээс олж харч болно. Эдгээр нь орчин үеийн илчлэлтүүдэд ч бас бий. Эдгээрийг Түүний заасан сургаал бүрээс олж харч болно. Эдгээр нь орчин үеийн илчлэлтүүдэд ч бас бий.

Тэнгэр дэх Эцэг маань өчигдөр, өнөөдөр мөн үүрд адил байх болно. Бошиглогч Мормон бидэнд Бурхан бол “бүх үүрд мөнхөөс бүх үүрд мөнхөд өөрчлөгдөшгүй” гэж хэлсэн байдаг.<sup>3</sup> Бараг л бүх зүйл өөрчлөгдөж байгаа дэлхий дээр Түүний тууштай байдал нь үл таних усанд живэлгүй үлдэхэд туслах зангуунаас чанга зуурч, аюулгүй байх найдварыг өгнө.

Заримдаа сүмээс гадна дэлхийд байгаа хүмүүс та нараас ч илүү аз жаргалтай, баяр хөөртэй санагдаж магадгүй. Заримдаа Сүмд дагаж, мөрддөг зүйлс та нарын эрх чөлөөг хязгаарлаад байгаа юм шиг санагдаж болно. Ах эгч нар аа, гэсэн хэдий ч Аврагчийг дагаж, зарлигуудыг сахиснаар ирэх Сүнснээс өөр юу ч жинхэнэ баяр баясгалан, амар амгаланг авчирч чадахгүй

гэдгийг би тунхаглаж байна. Энэ Сүнс нь дэлхийн олон янзын үйл явдалд оршиж чадахгүй. Төлөөлөгч Паул үнэнийг тунхаглахдаа “Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээн авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь мунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг” гэжээ.<sup>4</sup> Хэрэв бид өөрсдийгөө ийм байлгахыг зөвшөөрөх юм бол бидний хэн ч гэсэн *төрөлх хүн* болж болно.

Сүнслэг зүйлсээс хэт их холдсон дэлхийд бид болгоомжтой байх ёстой. Бидний жишигт нийцэхгүй аливаа зүйлсээс татгалзах нь маш чухал. Учир нь тэдгээр нь бидний хамгийн их хүсдэг Бурханы Хаант Улс дахь мөнх амьдралыг хүлээн авахад саад болдог юм. Амьдралын шуурга нь бидний мөнх бусд оршихуын зугтаж үл болох хэсэг учир цагаас цагт бидний хаалгыг тогшоор л байх болно. Хэрэв бид сайн мэдээг амьдралынхаа төв болгож, Аврагчийн хайрыг зүрх сэтгэлдээ тээж явбал шуурга бүртэй тулгарах үедээ суралцаж, тэдгээрийг илүү бэлтгэлтэйгээр даван туулах болно. Бошиглогч Исаиа “Үнэн зөвийн үйлс нь амар тайван байж, үнэн зөвийн үйлчлэл нь үүрдийн амар амгалан, аюулгүй байдал болох юм” хэмээн тунхаглажээ.<sup>5</sup>

Дэлхийд байвч дэлхийнх биш байхын тулд Тэнгэрлэг Эцэгтэйгээ залбирлаар дамжуулан ярих нь маш чухал билээ. Тэр биднийг ингээсэй гэж хүсдэг бөгөөд бидний залбиралд хариулах болно. 3 Нифай 18-р бүлэгт бичиглэсний дагуу Аврагч бидэнд “та нар уруу таталтанд орохгүйн тулд үргэлж сэрэмжилж мөн залбирах ёстой; учир нь Сатан та нарыг эзэмдэхийг хүсч байна. . . .

Тиймийн тул та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой;

Мөн та нар хүлээж авах болно гэж итгээд, миний нэрээр Эцэгээс гуйх, зөв болох юу боловч, болгоогтун энэ нь та нарт өгөгдөх болно” хэмээн анхааруулсан.<sup>6</sup>

Би 12 настай байхдаа залбирлын

хүчний талаар гэрчлэлтэй болсон юм. Би маш шаргуу ажиллаж, мөнгө цуглуулаад 5 доллар хадгалсан юм. Энэ нь Агуу Хямралын үе байсан тул 12 настай хөвгүүний хувьд таван доллар гэдэг асар их мөнгө байлаа. Би 5 доллартай тэнцэх бүх зоосон мөнгөө аавдаа өгсөн бөгөөд тэр 5 долларын дэвсгэрт болгоод надад эргүүлж өгсөн юм. Би тэр мөнгөөр чухал зүйл авахаар төлөвлөж байснаа мэддэг ч энэ олон жилийн дараа яг юу байсныг нь санахгүй байна. Би тэр мөнгө миний хувьд үнэхээр үнэ цэнэтэй байсныг л санадаг.

Тэр үед манай гэрт угаалгын машин байхгүй байсан болохоор ээж маань долоо хоног бүр хувцсаа угаалгын газарт өгдөг байсан юм. Хэдэн өдрийн дараа бидний нэрлэж заншсанаар “нойтон угаалга” бидэн дээр ирж, ээж маань тэдгээрийг хатаахаар байшингийн ард өлгөдөг байлаа.

Би 5 доллараа жинсэн өмднийхөө халаасанд хийсэн байлаа. Та нарын таамаглаж байгаагаар би өмднийхөө халаасанд мөнгөө хийгээд угаалгын газар руу явуулсан байсан юм. Би юу болсныг мэдэнгүүтээ маш ихээр санаа зовж билээ. Угаалгын газар угаахаасаа өмнө халааснуудыг тогтмол шалгадаг байсныг би мэдэж байлаа. Хэрэв мөнгийг анзааралгүй угаалганд оруулчихвал угаалгын машинаар угаах явцад мөнгө халааснаас унаж, эцэст нь угаалгын газрын ажилтан олоод эргүүлж өгөхийг хүссэн ч эзнийг нь олоход хэцүү байх болно. Таван доллараа эргүүлж олж авах ямар ч боломж байсангүй. Халаасандаа мөнгөө орхисноо хэлэхэд ээж маань олох боломжгүйг надад дахин баталж өгсөн юм.

Би тэр мөнгийг эргүүлж авахыг хүсч байлаа. Тэр мөнгө надад хэрэгтэй байсан. Би тэр мөнгийг олохын тулд маш шаргуу хөдөлмөрлөсөн. Надад хийж чадах ганцхан л зүйл байгааг би ухаарсан юм. Би Тэнгэрлэг Эцэгт хандан нойтон угаалгыг иртэл миний мөнгийг ямар

нэгэн байдлаар халаасанд маань үлдээж өгөхийг гуйлаа.

Маш удаан өнгөрсөн хоёр өдрийн дараа угаалгын газрын машин хувцсыг маань авчирч өгөх үеэр би цонх ширтэн хүлээж суулаа. Ачааны машин манайхыг чиглэн ирэх үед миний зүрх хүчтэй цохилж байв. Нойтон хувцаснуудыг байшинд оруулж ирэнгүүт би жинсэн өмдөө аваад өрөө рүүгээ гүйлээ. Тэгээд би чичирсэн гараараа халаасаа ухав. Би тэр даруйд юу ч олоогүй учир мөнгөө алджээ гэж бодов. Тэгтэл хуруунд маань нойтон таван доллар тэмтрэгдлээ. Тэгээд мөнгөө халааснаасаа гаргах үед би тайвширч билээ. Тэр миний залбиралд хариулсан гэдгийг мэдэж байсан тул би Тэнгэр дэх Эцэгтээ зүрх сэтгэлийнхээ угаас талархлын залбирал хэлж билээ.

Тэр цагаас хойш тоолж баршгүй олон залбирал маань хариулагдсан юм. Тэнгэр дэх Эцэгтэйгээ залбирлаар дамжуулан харилцаагүй нэг ч өдөр байгаагүй юм. Энэ харилцаагүйгээр би алдагдах байсан учраас үүнийг би дээдлэн хайрладаг. Хэрэв та нар Тэнгэр дэх Эцэгтэйгээ ийм харилцаатай биш бол би та нарыг зорилго тавин ажиллаж эхлээсэй гэж хүсч байна. Хэрэв бид үүнийг хийвэл аяллынхаа туршид сүнслэг байдлаа хадгалахад туслах Түүний сүнслэг нөлөөлөл хийгээд удирдамжийг амьдралдаа хүлээн авах эрхтэй болох болно. Хэрэв бид зөвхөн эрэлхийлэх аваас ийм сүнслэг нөлөөлөл, удирдамжууд нь бидэнд үнэ төлбөргүйгээр өгөгддөг бэлэг юм. Тэдгээр нь ямар агуу эрдэнэс вэ!

Тэнгэрлэг Эцэг маань надтай Өөрийн сүнслэг нөлөөллөөр дамжуулан харилцах үед би гүнээ даруусч мөн ихэд талархалтай байдаг. Би үүнийг таньж, үүнд итгэж, үүнийг дагаж сурсан. Цагаас цагт би ийм сүнслэг нөлөөллийг хүлээн авсаар байдаг. Үнэндээ нэгэн сэтгэл хөдлөм үйл явдал 1987 оны 8 сард Германы Франкфуртын Ариун Сүмийг онцгойлон адислахад болсон юм. Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон

бидэнтэй онцгойлон адислалтын нэг бил үү хоёр өдөр хамт байгаад гэр рүүгээ буцсан юм. Иймээс үлдсэн хуралдаануудыг хөтлөх боломж надад олдсон билээ.

Бямба гарагт Франкфуртын Ариун Сүмийн бүсэд хамрагддаг Голландын гишүүдэд зориулсан хуралтай байлаа. Би Нидерландаас ирсэн гайхалтай удирдагч болох Петр Мюрлик ахтай дотно танилцсан байв. Хурал эхлэхийн өмнөхөн Мюрлик ах өөрийн Голланд гишүүдэд хандан үг хэлэх хэрэгтэй бүр тэр тусмаа хамгийн эхэнд ярих хэрэгтэй гэсэн онцгой мэдрэмж надад төрөв. Тэр өглөө би түүнийг ариун сүмд хараагүй учир Бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Карлос Е.Асай руу зурвас бичиж, уг хуралд Петр Мюрлик ах оролцож байгаа эсэхийг асуув. Хурлыг эхлүүлэхийн өмнөхөн Ахлагч Асайгаас Мюрлик ах хаа нэгтээ завгүй байгаа тул оролцогч дунд *байхгүй* харин маргааш цэргийн албан хаагчдад зориулан байгуулагдсан гадасныхантай хийх ариун сүмийн онцгойлон адислалтын хуралд оролцох болно гэдгийг хэлсэн зурвас авав.

Тэгээд би индэр дээр гарч, хүмүүсийг тавтай морилохыг уриад хөтөлбөрөө танилцуулах зуур Петр Мюрлик ахыг эхний үг хэлэгчээр зарлах ёстой гэсэн гарцаагүй илчлэлтийг дахин хүлээж авсан юм. Энэ нь Мюрлик ах ариун сүмд *байхгүй* гэж Ахлагч Асайгын хэлсэн зүйлээс өөр зүйлийг хэлж байлаа. Гэвч би авсан илчлэлтэндээ итгэн хоор болон нээлтийн залбиралын дараа Петр Мюрлик ах үг хэлнэ хэмээн зарлав.

Би суудалдаа суугаад Ахлагч Асай руу зэрвэс харахад тэрээр түгшсэн нь илт байв. Тэр сүүлд нь Мюрлик ахыг эхний үг хэлэгчээр зарлахад өөрийнхөө чихэнд ч итгэж чадаагүйгээ хэлсэн юм. Намайг түүний зурвасыг уншсан гэдгийг мэдэж байсан тул ариун сүмийн хаа ч байхгүйг нь мэдсээр байж яагаад Мюрлик ахыг эхний үг хэлэгчээр зарласныг тэр ойлгохгүй байжээ.

Энэ үйл явдлын үеэр Петр Мюрлик ах Порстрассе дахь бүсийн оффис дээр цуглаанд оролцож байжээ. Цуглааны үеэр тэр гэнэт Ахлагч Бага Томас А.Хавкс руу хараад “Та намайг хэр хурдан ариун сүм рүү хүргэж өгч чадах вэ” гэж асуужээ.

Спорт загварынхаа жижиг машинаар ихэд хурдан давхих дуртай Ахлагч Хавкс “Би 10 минутын дотор л таныг хүргээд өгнө. Харин та яагаад ариун сүм явах хэрэгтэй гэж?” хэмээн хариулсан юм.

Мюрлик ах яагаад ариун сүм рүү явах хэрэгтэйгээ мэдэхгүй ч тэнд байх ёстойгоо мэдэж байна гэж хэлжээ. Тэгээд тэд тэр даруй ариун сүм рүү явахаар гарсан байна.

Найрал дуучид гайхамшигтайгаар дуулж байх хооронд би Петр Мюрлик ахыг харах байх гэж бодоод эргэн тойрноо гүйлгэн харж суув. Харин би түүнийг олж харсангүй. Гэсэн хэдий ч гайхалтай нь би ямар ч түгшүүр мэдрэхгүй байлаа. Би бүх зүйл сайхан болно гэсэн аятайхан, үгүйсгэхийн аргагүй баталгааг мэдэрч байсан юм.

Мюрлик ах нээлтийн залбирлын дараа ариун сүмийн гол хаалгаар яагаад тэнд байх ёстойгоо мэдэхгүй байсаар орж ирэв. Танхим дундуур яаран алхахдаа тэр миний дүрсийг дэлгэцэнд харж “Бид одоо Петр Мюрлик ахын үгийг сонсох болно” гэж хэлэхийг сонсжээ.

Удалгүй Петр Мюрлик ах өрөөнд орж ирэн индрийн өмнө байраа эзэлсэнд Ахлагч Асай гайхширч хоцорсон юм.

Хурал дууссаны дараа Мюрлик ах бид хоёр яагаад тэрээр үг хэлэх болсон тухай ярилцаж байлаа. Зөвхөн надад төдийгүй Петр Мюрлик ахад ирсэн сүнслэг нөлөөллийн талаар би тунгаан бодож билээ. Энэ гайхамшигтай үйл явдал надад илчлэлт хүлээж авах зохистой байж, ирсэн илчлэлтэд итгэн түүний дагуу үйлдэхийн чухлыг гэрчилсэн юм. Их Эзэн Франкфуртын Ариун Сүмийн онцгойлон адислалтад ирсэн тэдгээр хүмүүст өөрийн үйлчлэл Петр Мюрикийн сэтгэл

хөдөлгөм гэрчлэлийг сонсгохын тулд энэ бүхнийг хийсэн гэдгийг би мэднэ.

Хайрт ах эгч нар аа, Түүнд хандсан бидний залбирлууд, бидэнд өгдөг Түүний сүнслэг өдөөлт болон Тэнгэр дэх Эцэгтэйгээ харилцах харилцаа нь амьдралын шуурга, саад бэрхшээлүүдийг даван туулахад бидэнд нэн чухал юм. Их Эзэн “Надад ойр байгтун, мөн би та нарт ойр байх болно; намайг хичээнгүйлэн эрэлхийлэгтүн, мөн та нар намайг олох болно” хэмээн биднийг уридаг.<sup>7</sup> Үүнийг хийснээр бид “шилжин нүүлгэгдэлгүй . . . Ариун газар зогсож”, зөв шударгад хүчтэй, тууштай байх хүсэл хийгээд зоригийг өгөх Түүний Сүнсийг амьдралдаа мэдрэх болно.<sup>8</sup>

Өөрчлөлтийн салхи биднийг тойрон эргэлдэж, нийгмийн ёс суртахуун бидний нүдний өмнө сулран доройтож буй энэ үед Өөртөө найддаг хүмүүст өгсөн Их Эзний үнэт амлалтуудыг бид санах болтугай: “Би чамтай хамт байгаа тул бүү ай! Өөрийнхөө талаар санаа бүү зов. Учир нь Би чиний Бурхан. Би чамайг тэнхрүүлж, үнэхээр чамд тусална. Би заавал Өөрийн зөв баруун мутраар чамайг хамгаална.”<sup>9</sup>

Ямар гайхалтай амлалт вэ! Энэ нь бидний адислал байж хэмээн бидний Их Эзэн, Аврагч Есүс Христийн нэрээр чин сэтгэлээсээ залбирч байна, амен.

#### ЭШЛЭЛҮҮД

1. Жонатан Сакс, “Reversing the Decay of London Undone,” *Wall Street Journal*, 2011 оны 8-р сарын 20, [online.wsj.com](http://online.wsj.com); тэмдэглэгээ нэмэгдсэн. *Эшлэл*: Лорд Сакс нь Еврейчүүдийн Нэгдсэн Цуглааны Холбооны дээд рабби юм.
2. Египетээс гарсан нь 20:3–4, 7–8, 12–17.
3. Моронай 8:18.
4. 1 Коринт 2:14.
5. Исаиа 32:17.
6. 3 Нифай 18:18–20.
7. Сургаал ба Гэрээ 88:63.
8. Сургаал ба Гэрээ 87:8.
9. Исаиа 41:10.

# Бидний үед зориулсан сургаал болон хичээлүүд

**Д**өрөв дэх ням гарагийн Мелкизедек Санваартан болон Нийгмийн Халамжийн бүлгийн хичээл нь “Teachings for Our Time”-д төвлөрнө. Хичээлд бэлдэхдээ хамгийн сүүлийн ерөнхий чуулганаас нэг юм уу хоёр яриаг сонгож авч хичээлээ зааж болно (доорх хүснэгтийг харна уу). Гадас, дүүргийн ерөнхийлөгчид ерөнхий чуулганы яриаг сонгож эсвэл энэ үүргийг бишоп, салбарын ерөнхийлөгчид даалгаж болно. Мелкизедек Санваартнууд болон Нийгмийн Халамжийн бүлгийн эгч нар адилхан Ням гарагт адилхан хүний ярианаас судлахын үнэ цэнийг удирдагчид онцлон тэмдэглэх ёстой.

Эдгээр дөрөв дэх ням гарагийн хичээлийг судалж, ангид хамгийн сүүлийн ерөнхий чуулганы сэтгүүлийг авчрахыг гишүүдээс хүсч болно.

#### Ерөнхий Чуулганы ярианаас хичээл заахаар бэлтгэхэд өгөх зөвлөгөө

Ерөнхий Чуулганы яриануудаас суралцаж, хичээлээ заахад тань Ариун Сүнс тантай хамт

байхын төлөө залбир. Танд бусад материалыг ашиглаж хичээл заах санаа төрж мадаггүй гэхдээ ерөнхий чуулганы ярианууд хамгийн тохиромжтой хөтөлбөр юм. Сүмийн хамгийн сүүлийн ерөнхий чуулганд зааснаар Таны үүрэг бол бусдыг сайн мэдээнээс суралцаж, үүний дагуу амьдрахад туслах явдал юм.

Яриануудыг уншиж, ангийн гишүүдийн хэрэгцээнд тохирох зарчим, сургаалыг хай. Мөн түүх, судрын тайлбар болон танд эдгээр үнэнүүдийг заахад туслах яриануудыг хай.

Зарчим болон сургаалуудыг заах төлөвлөгөө гарга. Таны төлөвлөгөөнд ангийн гишүүдэд туслах асуултууд багтсан байх ёстой:

- Яриануудаас зарчим, сургаалуудыг хай.
- Тэдгээрийн утга учрыг нь тунгаа.
- Өөрийнхөө ойлгосон зүйлс, санаа бодол, туршлага, гэрчлэлийг хуваалц.
- Тэдгээр зарчим, сургаалуудыг амьдралдаа хэрэгжүүлэхийг урь.

САР БҮРИЙН ЗААХ ХИЧЭЭЛҮҮД	ДӨРӨВ ДЭХ НЯМ ГАРАГИЙН ХИЧЭЭЛИЙН МАТЕРИАЛУУД
2011 оны 11-р сараас 2012 оны 4-р сар	2011 оны 11-р сарын <i>Liahona</i> * дээр хэвлэгдэж гарсан ярианууд
2012 оны 5-р сараас 2012 оны 10-р сар	2012 оны 5-р сарын <i>Liahona</i> * дээр хэвлэгдэж гарсан ярианууд

\*Эдгээр яриануудыг олон хэл дээр [conference.lds.org](http://conference.lds.org) вэб хуудаснаас харах боломжтой.



**Ерөнхийлөгч Дийтер Ф.Угдорф**

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх

# Та нар Түүнд чухал

*Их Эзэн бодгалийн үнэ цэнийг дэлхийнхээс огт өөрөөр үнэлдэг.*

**Д**элхий дахины мэдэх хамгийн агуу бошиглогчдын нэг Мосег Фараогийн охин өсгөж, тэрээр өөрийн амьдралын эхний 40 жилийг Египетийн хаад дээдсийн хана хэрэм дотор өнгөрөөжээ. Тэрээр эртний хаант улсын агуу сүр жавхлантай байдлыг мэддэг байлаа.

Олон жилийн дараа Мосе агуу хүчит Египетийн сүрлэг байдал болон сүр жавхлангаас хол, аас холын нэгэн уулын орой дээр Бурханы оршихуйг очиж, Бурхантай нүүр тулан хоёр хүн хоорондоо ярьж байгаа мэтээр ярисан билээ.<sup>1</sup> Тэр үед Бурхан Мосед Өөрийн мутрын бүтэлийг харуулж, Өөрийн ажил болон алдар суунаас өнгөцхөн харуулсан байдаг. Тэрхүү үзэгдэл төгсөхөд Мосе олон цагийн туршид газар хэвтсэн билээ. Эцэст нь түүний хүч чадал сэргэхэд тэрээр Фараогийн зөвлөхөөр олон жилийн турш үйлчилж байхдаа огт бодож байгаагүй нэг зүйлийг ухаарчээ.

“Хүмүүн нь юу ч биш гэдгийг би мэднэ” хэмээн тэр хэлсэн юм.<sup>2</sup>

## **Бид өөрсдийн бодлогоос ч өчүүхэн**

Бид дэлхий ертөнцийн талаар илүү ихийг сурч мэдэх тусам Мосегийн мэдэж авсан зүйлсээс бага ч болтугай ухаардаг.

Дэлхий ертөнц асар том, тайлагдашгүй нууцлаг, үнэхээр агуу учраас хүмүүний оюун ухаанд багташгүй юм. Бурхан Мосед “тоо томшгүй олон дэлхийг бүтээсэн буюу би” гэж хэлжээ.<sup>3</sup> Шөнийн тэнгэрийн гайхамшигт төрх нь энэхүү үнэнийг гэрчилдэг.

Шөнийн харанхуй тэнгэрт далай тэнгис, тивийг туулан нисэхдээ нисгэгчийн цонхоор сая сая оддын гайхамшигийг харах шиг гайхамшигт зүйл надад цөөн тохиож байсан.

Одон орны судлаачид орчлон ертөнц дэх оддыг тоолохыг оролдож байсан удаатай. Нэг бүлэг судлаачид бидний телескопоор олж харж чадах оддын тоо нь дэлхий дээрх бүх говь цөл болон далайн эрэг дээрх элсний ширхэгээс 10 дахин их гэж таамагласан байна.<sup>4</sup>

Энэхүү дүгнэлт нь эртний бошиглогч Энохын дараах тунхаглалтай ойролцоо юм “Дэлхийн маш жижиг хэсгүүдийг, тийм ээ, үүн лугаа адил сая

сая дэлхийг хүн тоолж чадах боломжтой байсансан бол, энэ нь таны бүтээлтүүдийн тоонд эхлэл байхгүй байхсан”.<sup>5</sup>

Бурханы бүтээлүүдийн агуу ихийг бодохоор агуу Хаан Бенжамин өөрийн хүмүүст “Бурханы агуу ихийг, мөн өөрсдийнхөө юу ч биш болохыг үргэлж дурсан санаарай” хэмээн зөвлөсөнд гайхах зүйл байхгүй билээ.<sup>6</sup>

## **Бид өөрсдийн бодсоноос ч агуу**

Хүмүүн нь юу ч биш мөртлөө “Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу гэдгийг” бодоод би гайхширдаг.<sup>7</sup>

Бид агуу их орчлон ертөнцийг хараад “бүтээлтийн агуу байдлын хажууд нь хүмүүн юухан билээ” гэж хэлж болох хэдий ч Бурхан орчлон ертөнцийг бүтээсэн гол шалтгаан нь хүмүүн бид билээ. Бурхан Өөрөө дэлхийг бүтээсэн шалтгаан нь хүмүүн бид гэдгийг хэлсэн юм! Түүний ажил мөн алдар суу энэхүү агуу гайхамшигт орчлон ертөнцийн зорилго нь хүмүүн төрөлхтнийг аварч мөн өргөмжлөх явдал билээ.<sup>8</sup> Өөрөөр хэлбэл мөнх амьдралын өгүүлшгүй агуу байдал, эцэс төгсгөлгүй огторгуй, цаг хугацааны алдар суу болон нууцлаг байдал нь та бид нар шиг эгэл хүмүүний төлөө бүтээгдсэн юм. Түүний охид, хөвгүүдийн хувьд бид өөрсдийн чадавхиа бүрэн ашиглаж болохын тулд Тэнгэрлэг Эцэг маань орчлон ертөнцийг бүтээсэн билээ.

Энэ нь хүмүүний хувьд зөрчилдөөнтэй зүйлс: Бурхантай харьцуулахад хүмүүн нь юу ч биш; гэхдээ Бурханы хувьд бид хамгийн чухал. Хэмжээ хязгааргүй бүтээлтэй

харьцуулахад бид нар юу ч биш байж болох ч бидний цээжинд мөнхийн гал бадарч байдаг. Бид эцэс төгсгөлгүй ертөнц хэмээх ойлгож баршгүй агуу амлагдсан өргөмжлөлд хүрэхэд ойрхон байна. Түүнд хүрэхэд бидэнд туслах нь Бурханы агуу хүсэл билээ.

### Бардамналын мунхаглал

Бурханы хүүхдүүдийг төөрөлдүүлэх хамгийн үр нөлөөтэй арга нь хүмүүний агуу, өчүүхэн гэсэн зөрчилдөөнтэй хоёр зармыг аль нэг тал руу нь хэтрүүлэх гэдгийг хууран мэхлэгч Сатан мэддэг. Зарим хүмүүсийн хувьд Тэрээр тэдний бардамналыг өдөөн тэднийг ялагдашгүй, дийлдэшгүй, бусдаас онцгой гэдэгт итгүүлдэг. Тэр тэдний чадвар, эрх мэдэл, амьдралын төвшин өндөр учир тэд бусдаас илүү, онцгой бөгөөд эргэн тойронд байгаа бусдыг хэмжих нийтлэг хэмжүүр тэдэнд хамаагүй гэж итгүүлдэг. Тиймээс тэд хэний ч дүрэм журамд захирагдаагүй бөгөөд өөр хэн нэгний асуудалд санаа зовох шаардлаггүй гэж үздэг.

Абрахам Линколныг дараах шүлэгт дуртай байсан гэж ярьдаг:

*Мөнх бус хүний сүнс нь бардам  
байхын шалтгаан нь юу вэ?  
Хурдлан одох солир, хурдан  
өнгөрөх үүл  
Цахилах цахилгаан, өнгөрөх  
давалгааны адил  
Хүмүүн нь амьдралаас булшинд  
амрахаар ордог.<sup>9</sup>*

Мөнх амьдралтай харьцуулахад энэ мөнх бус амьдрал нь өчүүхэн “хэсэг хугацаа” гэдгийг Есүс Хритийн дагалдагчид ойлгодог.<sup>10</sup> Дэлхийнхний чухалчлан үздэг зүйл нь үнэндээ бодгалын хэмжүүртэй огт хамаараагүй гэдгийг тэд мэддэг. Бүхэл дэлхийн мөнгийг цуглуулаад ч тэнгэр дэх ганц талхыг худалдаж авч чадахгүй гэдгийг тэд мэддэг.

“Бурханы хаант улсыг өвлөх”<sup>11</sup> тэдгээр нь “хүүхэд шиг хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй,

хайраар дүүрэн” тэд байдаг.<sup>12</sup> “Учир нь өөрийгөө өргөмжилдөг аливаа хүн номхруулагдаж, өөрийгөө даруу байлгагч нь өргөмжлөгдөнө.”<sup>13</sup> “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа” хэрэг гэдгийг тэрхүү дагалдагчид бас ойлгодог юм.<sup>14</sup>

### Биднийг мартаагүй

Сатан биднийг сэтгэл санааны уналтаар дамжуулан хуурч мэхэлдэг. Тэрээр өөрсдийнхөө үнэ цэнэд гэдэгт эргэлзэж эхлэх хүртэл биднийг өөрсдийгөө чухал биш гэж бодуулахыг хичээдэг. Тэрээр та нар хэнд ч анзаарагдахгүй өчүүхэн бөгөөд та нарыг мартсан бүр Бурхан хүртэл та нарыг мартсан гэж бидэнд хэлдэг.

Өөрсдийгөө чухал биш, үнэ цэнэгүй, ганцаардмал, мартагдсан гэж бодож байгаа хүмүүст тус болох хувийн туршлагаасаа би та нарт хуваалцъя.

Олон жилийн өмнө би Америкийн Нэгдсэн Улсын Нисэх хүчинд нисгэгчийн сургалтанд суусан юм. Чехословакт төрөөд Зүүн Германд өсөж торнисон, англи хэлээр арай л гэж ярьдаг байсан Баруун Германы залуу цэрэг би өөрийн гэр орноос маш хол байлаа. Техасд байдаг сургалтын төв рүү явсан аяллаа би маш тод санадаг. Би онгоцонд Америкийн зүүн урд хэсгийн аялгаар ярьдаг зорчигчийн хажууд сууж байлаа. Би түүний хэлсэн үгсийг бараг л ойлгохгүй байсан юм. Би ер нь буруу хэл заалгаад байсан юм биш биз дээ гэж бодоход хүрлээ. Нисгэгчийн сургалтанд хэдхэн орон тоо дутуу байсан бөгөөд үүний төлөө төрөлхийн англи хэлтэй оюутнуудтай өрсөлдөнө гэж бодохоос ч аймшигтай санагдаж байлаа.

Техас мужийн Том Булаг хэмээх жижигхэн хотын цэргийн бааз дээр ирээд би Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн салбарыг хайж олсон бөгөөд уг салбар

нь нислэгийн бааз дахь өрөөг түрээслэн цуглаана явуулдаг хэдэн гайхамшигтай гишүүдээс бүрдсэн байлаа. Уг гишүүд Сүмийн байнгын цуглааны байр болгож ашиглах нэгэн жижиг байшинг барьж байсан юм. Тэр үед шинэ цуглааны байр барих ажлын ихэнхийг гишүүд хийж гүйцэтгэдэг байжээ.

Би өдрөөс өдөрт нисгэгчийн сургалтандаа сууж, хамаг чадлаараа хичээлээ давтаж, чөлөөт цагийнхаа ихэнхийг цуглааны байрыг барихад зориулж байсан юм. Тэнд л би хоёр дөрөв гэдэг нь бүжгийн алхам биш харин модон банзны хэмжээ гэдгийг сурсан. Мөн би эрхий хуруугаа цохихгүйгээр хадаас хадах амьдралын чухал чадварыг эзэмшсэн юм. Би тэр цуглааны байрыг барилцахад маш их цаг зарцуулдаг байсан болохоор манай нислэгийн багш нарын нэг байсан салбарын ерөнхийлөгч маань намайг хичээлээ давтахад илүү их цаг зарцуулах хэрэгтэй гэдгийг мөн миний төлөө санаа нь зовниж байгааг хэлсэн юм.

Миний найз нар болон хамт сурч байсан ангийнхан маань чөлөөт цагаараа янз бүрийн үйл ажиллагаанд явдаг байсан ба тэдний хийдэг зарим зүйл нь өнөөдрийн *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд нийцэхгүй үйл ажиллагаанууд байсан юм. Миний хувьд баруун Техасын жижигхэн салбарын идэвхтэй гишүүн байж, шинээр сурсан дархны арга барилдаа дадлагажиж, ням гарагийн анги болон ахлагчдын чуулгад хичээл заах дуудлагаа гүйцэлдүүлэх явцдаа англи хэлний мэдлэгээ дээшлүүлж байгаадаа баяртай байлаа.

Тэр үед Том Булаг гэдэг газар нь нэрэндээ тохироогүй, жижигхэн, чухал биш, танигдаагүй газар байлаа. Мөн олонтоо би өөрийгөө үүний адил чухал биш, хэн ч танихгүй, ганцаардмал нэгэн гэж боддог байсан. Хэдийгээр тэгж боддог байсан ч гэсэн Их Эзэн намайг мартсан болов уу эсвэл

Тэр намайг энэ газраас олж чадах болов уу гэж хэзээ ч би эргэлзэж байгаагүй юм. Миний хаана байх нь мөн анги дундаа хэр сайн сурагч гэдэг нь эсвэл Сүмд ямар дуудлагатай эсэх нь Тэнгэрлэг Эцэгийн хувьд чухал биш гэдгийг би мэдэж байлаа. Харин чадлынхаа хэрээр хөдөлмөрлөж, зүрх сэтгэлээ Түүнд хандуулж, өөрийн эргэн тойрондоо байгаа хүмүүст туслахад бэлэн байх нь л Түүнд чухал юм. Хэрэв чадах бүхнээ хийвэл бүх зүйл сайхан болно гэдгийг би мэдэж байсан юм.

Бүх зүйл нь сайхан болсон юм.<sup>15</sup>

### **Эцсийнх нь эхнийх байх болно**

Бид өөрсдийн өдрийг гангиг чулуун ханан дотор эсвэл малын хашаанд ажиллаж өнгөрөөж байгаа эсэх нь Их Эзэнд чухал биш. Бидний нөхцөл байдал ямар байх нь хамаагүй Тэр бидний хаана байгааг мэддэг. Тэр Өөрийн арга замаар мөн Өөрийн ариун зорилгуудын төлөө Өөрт нь зүрх сэтгэлээ хандуулах тэднийг зэмсэгээ болгох болно.

Хамгийн агуу бодгалиудын зарим нь түүхийн цэдгэнд нэрээ үлдээхгүй гэдгийг Бурхан мэддэг. Тэд Аврагчийн жишээг харуулж, өөрсдийн амьдралын өдрүүдийг сайныг үйлдэхэд зориулсан адислагдсан, даруу бодгалиуд билээ.<sup>16</sup>

Найзын маань эцэг эх энэхүү зарчмын үлгэр жишээг надад харуулсан юм. Нөхөр нь Юта дахь гангийн үйлдвэрт ажилладаг байсан ба өдрийн хоолны цагаар судраа эсвэл Сүмийг сэтгүүлийг гаргаад уншдаг байжээ. Бусад ажилчид түүнийг хараад шоолж, итгэлийг нь басамжилдаг байсан гэнэ. Тэднийг тэгэх бүрт тэрээр найрсагаар, итгэлтэйгээр тэдэнтэй яридаг байжээ. Тэдний хүндэтгэлгүй байдал түүнийг уурлуулж, сэтгэлээр унагахыг тэр зөвшөөрөөгүй билээ.

Олон жилийн дараа үгээр дайран шоолдог байсан хүмүүсийн

нэг нь маш хүндээр өвдсөн гэнэ.

Тэрээр насан эцэслэхийнхээ өмнө тэрхүү даруухан хүнийг өөрийнх нь оршуулах ёслол дээр үг хэлэхийг хүссэн ба тэр хүссэнээр нь үйлджээ.

Сүмийн энэхүү итгэлтэй гишүүн нийгмийн байр суурь эсвэл эд хөрөнгөний хувьд агуу нэгэн байгаагүй ч түүний нөлөө түүнийг таньж мэддэг байсан бүх хүмүүст нөлөөлсөн юм. Тэрээр цасанд шигдсэн өөр нэгэн ажилчинд туслахаар зогсоод үйлдвэрийн ослоор нас барсан юм.

Нэг жилийн дотор түүний бэлэвсэн эхнэр тархины мэс засалд орсон ба дараа нь алхах чадваргүй болжээ. Гэсэн хэдий ч хүмүүс түүн дээр ирж, хамт байх дуртай байсны учир нь тэр бусдыг сонсдог байсан. Тэр бусдыг санадаг байсан. Тэр бусдад санаа тавидаг байсан. Бичих чадвараа алдсан ч гэсэн тэр хүүхдүүд, ач зээ нарынхаа утасны дугаарыг цээжээр мэддэг байсан. Тэр бусдын төрсөн өдөр, онцгой тэмдэглэлт баярыг санадаг байсан.

Түүн дээр ирсэн хүмүүс амьдрал болон өөрсдийнхөө талаар илүү өндөр сэтгэгдэлтэй болоод буцдаг байсан юм. Тэд түүний хайрыг мэдэрдэг байсан. Тэд түүнийг өөрсдөд нь санаа тавьж байгааг мэддэг байсан. Тэр хэзээ ч гомдолдоггүй байсан бөгөөд өөрийнхөө амьдралыг бусдын амьдралыг адислахад зориулсан юм. Тэр Есүс Христийн амьдрал болон хайрыг үнэхээр үлгэр жишээгээрээ үзүүлдэг цөөхөн хэдэн хүмүүсийн нэг гэж түүний найз хэлсэн байдаг.

Тэрхүү хосууд хамгийн түрүүнд өөрсдийгөө чухал биш хүмүүс гэж хэлэх байсан байх. Гэхдээ Их Эзэн бодгалийн үнэ цэнийг дэлхийнхээс огт өөрөөр үнэлдэг. Тэр тэрхүү итгэлтэй хосыг мэддэг; Тэр тэдэнд хайртай. Тэдний үйлдэл нь Түүнд итгэх баттай итгэлийнх нь амьд гэрч билээ.

### **Та Түүнд Чухал**

Ах эгч нар аа, орчлон ертөнцийн асар агуутай харьцуулахад хүмүүн нь юу ч биш гэдэг нь үнэн байж болно. Заримдаа бид чухал биш, анзаарагдахгүй байгаа мэт, ганцаараа эсвэл мартагдсан мэт санагдаж болно Гэхдээ та нар Түүнд чухал гэдгээ үргэлж санаж байгаарай! Хэзээ нэгэн цагт үүнд эргэлзэх юм бол эдгээр дөрвөн бурханлиг зарчмыг санаарай:

Нэгдүгээрт, Бурхан даруу номхон тэдэнд хайртай, учир нь тэд “тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь” билээ.<sup>17</sup>

Хоёрдугаарт, “Өөрийн сайн мэдээний бүрэн байдлыг сул доройчууд хийгээд эгэл борчуудаар дэлхийн хязгааруудад тунхаглуулахаар” Их Эзэн итгэмжлүүлдэг.<sup>18</sup> Тэрээр “хүчит юмсыг ичээхийн тулд” мөн “дэлхийн сул дорой зүйлүүд урагш гарч ирэх бөгөөд хүч чадалтнууд хийгээд хүчтэнүүдийг унагахаар”<sup>19</sup> сонгосон.<sup>20</sup>

Гуравдугаарт, та хаана амьдарч, ямар цалинтай ямар ажил хийдэг эсвэл хэр их авьяас чадвартай, хэр их үзэсгэлэнтэй, Сүмд ямар дуудлагатай байх нь хамаагүй Тэнгэрлэг Эцэг та нарыг үргэлж харж байдаг юм шүү. Тэр та нарт хайртай. Тэр таны эелдэг даруу сэтгэл, хайрын үйлчлэлийг мэддэг. Тэдгээр нь нийлээд таны үнэнч байдал, итгэлийн дуусашгүй гэрч болдог билээ.

Эцэст нь дөрөвдүгээрт, одоо таны харж, мэдэрч байгаа зүйлс мөнхөд нэг хэвээрээ үлдэхгүй гэдгийг ойлгоорой. Та ганцаардмал байдал, гуниг, өвчин зовлон, сэтгэл гутралыг мөнхөд мэдрэхгүй. Бурханд зүрх сэтгэлээ хандуулах тэднийг Тэрээр мартаж, орхихгүй гэсэн Бурханы итгэмжит амлалт бидэнд байдаг билээ.<sup>21</sup> Тэрхүү амлалтанд итгэх итгэл, найдвартай байгаарай. Тэнгэрлэг Эцэгээ хайрлаж, үг үйлсээрээ Түүний дагалдагч болоорой.

Хэрэв та тэвчээртэй байж, Түүнд

итгэн, зарлигуудыг итгэлтэйгээр үргэлжлүүлэн сахих аваас нэгэн өдөр Төлөөлөгч Паулд өгөгдсөн “Нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй, Хүний санаанд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ” гэх амлалтуудыг эдлэх болно гэдэгт итгэлтэй байгаарай.<sup>22</sup>

Ах эгч нар аа, орчлон ертөнц дээр хамгийн хүчирхэг Нэгэн бол та нарын сүнсний Эцэг билээ. Тэр таныг мэддэг. Тэр таныг төгс хайраар хайрладаг.

Бурхан таныг нэгэн жижигхэн гараг дээр түр хугацаагаар амьдарч байгаа зуурдын нэгэн бодгаль гэдгээр биш харин Өөрийн хүүхэд гэдэг үүднээс хардаг. Тэрээр таныг ирээдүйд хэн болж чадахаар тань

хардаг. Тэрээр та Түүнд хэчнээн чухал болохыг мэдээсэй гэж хүсдэг.

Бид итгэж найдан, амьдралаа Түүнтэй ницүүлээсэй ингэснээр бид өөрсдийн мөнхийн үнэ цэнэ, боломж чадвараа ойлгох болно. Бид Тэнгэрлэг Эцэгийн бидэнд нөөцөлсөн агуу адислалуудыг авах зохистой байгаасай хэмээн би Түүний Хүү, Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.

#### **ЭШЛЭЛҮҮД**

1. Моце 1:2-г үз.
2. Моце 1:10.
3. Моце 1:33.
4. Андроу Крэйг, “Astronomers count the stars,” BBC News, 2003 оны 7-р сарын 22, <http://news.bbc.co.uk/2/hi/science/nature/3085885.stm>-г үз.
5. Моце 7:30.

6. Мозая 4:11.
7. Сургаал ба Гэрээ 18:10.
8. Моце 1:38–39-г үз.
9. Виллиам Нокс, “Mortality,” in James Dalton Morrison, ed., *Masterpieces of Religious Verse* (1948), 397.
10. Сургаал ба Гэрээ 121:7.
11. 3 Нифай 11:38.
12. Мозая 3:19.
13. Лук 18:14; мөн шүлэг 9–13-г үз.
14. Мозая 2:17.
15. Дийтер Ф.Угдорф ангийнхаа шилдэг сурагч болон төгсжээ.
16. Үйлс 10:38-г үз.
17. Матай 18:4; мөн шүлэг 1–3-г үз.
18. Сургаал ба Гэрээ 1:23.
19. Сургаал ба Гэрээ 1:19.
20. 1 Коринт 1:27.
21. Еврей 13:5.
22. 1 Коринт 2:9.

© 2011 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи хэлний зөвшөөрөл: 6/10. Орчуулгын зөвшөөрөл: 6/10. *Visiting Teaching Message, November 2011* -ын орчуулга. Mongolian. 09711 363